



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019 08 29 № 05/6956  
танай 2019 08 22 ны № 01/2435 -т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлгийг хянасан тухай

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ДЭД ДАРГА  
Б.ЗАЯАБАЛ ТАНАА

*Handwritten signature and date: 2019/8/28*

Татварын ерөнхий газрын Татварын хяналт шалгалт, арга зүйн газрын татварын улсын ахлах байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Батбаатарын Цогтбаатар, Татварын үйлчилгээний төвийн өр дуудах төвийн татварын улсын ахлах байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Сүрэнжавын Оюунгэрэл нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн нэр дэвшигч нар нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ  
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ  
ДАРГА, АХЛАХ КОМИССАР



Л.СҮХ-ОЧИР

*Handwritten signature and date: 2019/08/30*